

Гарчиг

Төслийн тодорхойлолт.....	1
Төслийн нэр.....	1.1
Төслийн зорилго.....	1.2
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг.....	1.3
Төслийн байршил.....	1.4
Төслийн бүтэц, хүчин чадал.....	1.5
Орд газрын өнөөгийн байдал.....	1.6
Уулын хэсэг.....	2
Уурхайн хил хязгаар.....	2.1
Ашиглалтын нөөц.....	2.2
Уурхайн жилийн хүчин чадал.....	2.3
Уулын олборлолт явагдах ашиглалтын хугацаа.....	2.4
Уурхайн олборлолт ба капитал ажил.....	2.5
Ашиглалтын систем түүний үндсэн хэмжигдэхүүнүүд.....	2.6
Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын тооцоо.....	2.7
Төслийн гол болзошгүй сөрөг нөлөөлөл.....	3
Төслийн хэрэгжих орчин уур амьсгалийн нөхцөл.....	3.1
Агаарын температур.....	3.2
Салхи.....	3.3
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	4
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	5
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	6
Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	7
Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	8
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	9
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	10
Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө.....	11
Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	12
Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө.....	13
Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	14



1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Төслийн нэр

MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг ашиглах”

1.2. Төслийн зорилго

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших Төмөртэйн голын MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах бодитой болон боломжтой (B+C) зэргийн геологийн нөөц 15566.71 мян.тн хүдэр байгаад тулгуурлан уг ордыг ашиглан ордыг аж ахуйн эргэлтэд оруулах.

1.3. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр, хаяг

Төсөл хэрэгжүүлэгч: “Эрдэс групп” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011105077

Регистрийн дугаар: 5145783

Хаяг: УБ хот, СБДүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Эн Си Пи ХХК-н байр

Утас: +976-11-331107

Факс: +976-11-331102

1.4. Төслийн байршил, ерөнхий тойм зураг

“Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ашиглах” төслийн талбай нь газарзүйн байршлаар Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт Дархан хотоос зүүн зүгт 144 км, Улаанбаатар хотоос хойд зүгт 381 км, Хүдэр сумаас баруун урагшаа 30 км зайд байрлана.


MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь дараах солбицлоор хязгаарлагдана.

Талбайн солбицолууд

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг			Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1	107	13	46.18	49	40	16.96	12	107	14	31.34	49	40	48.0
2	107	13	51.02	49	40	21.54	13	107	14	35.43	49	40	49.3
3	107	13	54.04	49	40	25.51	14	107	14	38.73	49	40	49.82



4	107	13	57.72	49	40	28.92	15	107	14	41.27	49	40	49.99
5	107	14	1.17	49	40	32.01	16	107	14	43.61	49	40	50.72
6	107	14	6.41	49	40	36.27	17	107	14	46.99	49	40	52.98
7	107	14	11.55	49	40	38.41	18	107	14	48.04	49	40	53.46
8	107	14	12.29	49	40	41.02	19	107	14	57.03	49	40	54.93
9	107	14	18.21	49	40	43.03	20	107	15	1.31	49	40	55.96
10	107	14	24.41	49	40	44.58	21	107	12	31.32	49	40	55.96
11	107	14	29.01	49	40	46.38	22	107	12	31.32	49	40	16.96



Төслийн байршил /Сэлэнгэ аймаг, Хүдэр сум/

1.5. Төслийн хүчин чадал, бүтэц, бүрэлдэхүүн

Ордын уул техникийн нөхцөл, нөөцийн хэмжээ, хүчин чадал зэргийг үндэслэн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор ашиглалтын I жилд 465.1 мян.тн, II жилд 750.0 мян.тн, удаах жилүүдэд жил тус бүр 1000.0 мян.тн хүдэр олборлон баяжуулах хүчин чадал бүхий төслийг 17 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан.



1.5.1. Ил аргаар ашиглах үеийн уулын хэсэг


1.5.1.1. Ил уурхайн хүчин чадал

Уурхайн жилийн хүчин чадлыг үндэслэхдээ төсөл хэрэгжүүлэгчээс өгсөн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах техникийн даалгаварт өгсний дагуу эхний жилд 465.1 мян.тн, удаах жилд 750.0 мян.тн, 3 дахь жилээс 1000.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар нийт 8 жилийн хугацаанд ил уурхайг ашиглахаар тооцсон.

1.6 Орд газрын өнөөгийн байдал

Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг урьд онуудад ашиглаж байсан ба баруун хүдрийн биет дээр ил уурхайгаар хамгийн өндөр цэгээс ёроол хүртэлээ 98 м гүнзгийрч, бодитой В зэргээр 227.63 мян.тн хүдэр, боломжтой С зэргээр 88.2 мян.тн хүдэр олборлосон байна.

Зүүн хүдрийн биет дээр мөн ил уурхайгаар хамгийн өндөр цэгээс ёроол хүртэлээ 52 м гүнзгийрч, бодитой В зэргээр 373.2 мян.тн хүдэр, боломжтой С зэргээр 144.09 мян.тн хүдэр тус тус олборлосон байна.



Баруун хүдрийн биетийн одоо байгаа ил уурхайн хил хүрээ

2. УУЛЫН ХЭСЭГ

2.1 Уурхайн ашиглалтын хил хязгаар

2024 онд нийт 342.5 мян.м³ хөрс хуулж, 508.5 мян.тн хүдэр ил аргаар олборлоно. Тус онд ордын баруун биетэд хөрс хуулалт, хүдэр олборлолтын ажил явуулахаар төлөвлөж байна.

2.2 Ашиглалтын нөөц

Уурхайн ашиглалтын нөөцийг ТЭЗҮ-д тусгасанаар ашиглалтын үеийн хаягдал бохирдолтын хэмжээгээр тооцож авсан.

Ашиглалтын үед хүдрийн хаягдлыг 3,24%-иар, бохирдолтыг 5,02%-иар авч, ашиглалтын нөөцийг тооцсон.

2.3 Уурхайн жилийн хүчин чадал

Ил уурхайн хүчин чадлыг тооцохдоо карьерт ажиллах экскаваторын бүтээлийг гаргаж, уг бүтээлтэй уялдуулан бусад машин механизмын бүтээлийг сонгон авдаг аргачлалыг баримтлав.

2.4 Уулын ажил явагдах ашиглалтын хугацаа

Хөрс хуулалтын ажил 7-р сарын 1-нээс, хүдэр олборлолтын ажил 8-р сарын 1-нээс тус тус эхэлж, 9-р сарын 2-ны хооронд төлөвлөж байна.

Уулын хэсгийн ажиллах хоног:

VII/1 – IX/2-ны хооронд нийт төлөвлөн ажиллах хоног – 62 жил/хоног

Уулын ажил явагдах ашиглалтын хугацаа

	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Дүн
	Нийт ажиллах хоногийн тоо	Хоног	62
	Сард ажиллах хоногийн тоо	Хоног	31
	Хоногт ажиллах ээлжийн тоо	Ээлж	2
	1 ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	11



2.5 Уурхайн олборлолт ба капитал ажил

Өмнөх онуудын уулын ажлын нөлөөгөөр эвдрэлд өртсөн талбай болон 2023 онд уулын ажилд талбайг нэмж өртөхгүй, ашиглалт эхэлсэн үеээс өссөн дүнгээр нийт 45.7 га талбай болно.

Хөрс хуулалтын ажлыг явуулахдаа ашиглалтын түвшингүүдийг тэлэх замаар, хүдэр олборлолтыг суналын дагуу уулын ажлыг явуулна.

Баяжуулах үйлдвэрийг төмрийн хүдрээр тасралтгүй хангахын тулд хөрс хуулалтын ажлыг төлөвлөлтийн дагуу явуулж, 1 сар үйлдвэрлэхэд хүрэлцэхүйц байхаар хүдэр бэлдэж, овоолго үүсгэн нөөцлөнө. Уурхайн авто замыг “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн дагуу гүйцэтгэнэ.

2.6 Ашиглалтын систем, түүний үндсэн хэмжигдэхүүнүүд

Уулын чулуулгийг өрөмдөж тэслэн, сийрэгжүүлсэн уулын цулыг экскаватороор ачиж, автосамосвалаар хөрсийг гадаад овоолгод, хүдрийг баяжуулах үйлдвэрийн хүдрийн овоолгод тээвэрлэнэ.

Уурхайн үндсэн хэмжигдэхүүнүүд нь:

1. Ажлын бус доголын өндөр – 4 м
2. Ажлын доголын өндөр – 20 м
3. Хамгаалалтын тавцангийн өргөн - 2 м
4. Доголын налуугийн хэмжээ – 65-75°

3.7 Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын тооцоо.

1. 1-р үйлдвэр:

Хоногийн хүчин чадал (хүдрээр):

$$Q_{\text{үйлд}} = Q_{\text{үйлд}} * n * t = 120 \frac{\text{ТН}}{\text{Ц}} * 2 * 10 = 2400 \frac{\text{ТН}}{\text{хоног}}$$

Энд: $Q_{\text{үйлд}}$ – үйлдвэрийн хүчин чадал

n - Баяжуулах хэсгийн ээлжийн тоо

t - Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа



2-р үйлдвэр:

Хоногийн хүчин чадал (хүдрээр):

$$Q_{\text{үйлд}} = Q_{\text{үйлд}} * n * t = 130 \frac{\text{тн}}{\text{ц}} * 2 * 10 = 2600 \frac{\text{тн}}{\text{хоног}}$$

Энд: $Q_{\text{үйлд}}$ – үйлдвэрийн хүчин чадал

n - Баяжуулах хэсгийн ээлжийн тоо

t - Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа

2. Сарын хүчин чадал (хүдрээр):

$$Q_{\text{сар}} = Q_{\text{хон}} * N_{\text{сар}} = 2400 \text{тн} * 27_{\text{хон}} = 64800 \text{тн/сар}$$

$$Q_{\text{сар}} = Q_{\text{хон}} * N_{\text{сар}} = 2600 \text{тн} * 27_{\text{хон}} = 70200 \text{тн/сар}$$

$N_{\text{сар}}$ – сард ажиллах хоног/цах. ы саатал, цаг агаарын хүндэрлийг тооцсон хоног/ жилийн хүчин чадал

3. Жилийн хүчин чадал (хүдрээр):

$$Q_{\text{жил}} = Q_{\text{хон}} * N_{\text{жил}} = 2400 \text{тн} * 118 = 283200 \text{тн/жил}$$

$$Q_{\text{жил}} = Q_{\text{хон}} * N_{\text{жил}} = 2600 \text{тн} * 118 = 306800 \text{тн/жил}$$

$N_{\text{жил}}$ - жилд ажиллах хоног /цах. ы саатал, цаг агаарын хүндэрлийг тооцсон хоног /

3.1. Баяжуулах үйлдвэрийн техникүүдийн хүчин чадлын тооцоо.

1. CATD9R маркийн бульдозер: ажлын бүтээл жилд:

$$Q_{\text{буль}} = Q_{\text{ц}} * T * t * k_{\text{ц.а}}, \text{м}^3/\text{жил}$$

$Q_{\text{ц}}$ - цагийн бүтээл (40 м-т түрэх)

T - жилд ажиллах хоног

t - хоногт ажиллах хугацаа

$k_{\text{ц.а}}$ - ажлын цаг ашиглалтын коэффициент

$$Q_{\text{буль}} = 281 * 118 * 22 * 0.85 = 620.1 \text{ мян. м}^3/\text{жил}$$



2. CLG-856 маркийн дугуйт ачигч:

ээлжийн бүтээл:

$$Q_{\text{ээлж}} = \frac{3600 * E * k_{\text{ш}} * T * k_a * k_y}{t * k_c}$$

Энд: 3600 - цагийг секундээр илэрхийлсэн;

E -шанаганы багтаамж - 3 м³;

k_ш -шанага дүүргэлтийн коэффициент - 0.86;

T -хоногийн ажиллах хугацаа – 22 цаг;

k_a -ээлжийн цаг ашиглалтын коэффициент - 0,85;

k_y -ур чадварын коэффициент -0.8;

t -циклийн үргэлжлэх хугацаа -120 сек;

k_c -сийрэгжилтийн коэффициент - 1.4;

$$Q_{\text{ээлж}} = \frac{3600 * 3 * 0.86 * 22 * 0.85 * 0.8}{120 * 1.4} = 827.1 \text{ м}^3$$

$$\text{тонн-д шилжүүлвэл } Q_9 = 827.1 \text{ м}^3 * 2.45 \frac{\text{тн}}{\text{м}^3} = 2026 \text{ тн}$$

Ажиллах дугуйт ачигчийн тоо:

$$2\text{-р үйлдвэр: } N_{\text{ач}} = \frac{Q_{\text{х}}^{\text{үйлд}}}{Q_{\text{хон}}^{\text{ач}}} = \frac{2600 \text{ тн/хон}}{2026 \text{ тн/хон}} = 1.3$$

Нийт 4ш дугуйт ачигч хэрэглэгдэнэ.




3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Төслийн хэрэгжих орчны уур амьсгалын нөхцөл

Төсөл хэрэгжих Сэлэнгэ аймгийн Хүдэр сум орчмын нутгийн уур амьсгалыг тодорхойлж, үнэлэх судалгааны ажлын хүрээнд цаг уурын Хүдэр харуулын 2011-2020 оны мэдээг ашигласан болно. /Эх үүсвэр: Цаг Уур, Орчны Шинжилгээний Газар, Архив, Мэдээллийн Сангийн хэлтэс/

3.2. Агаарын температур

Төсөл хэрэгжих орчинд жилийн явцад агаарын температурын их утга нь зуны 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дүгээр сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур $+19.6^{\circ}\text{C}$ хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур -26.0°C байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур $+39.8^{\circ}\text{C}$ хүрч дулаарсан бол үнэмлэхүй хамгийн бага температур -45.2°C хүрч хүйтэрсэн байна.



Жилийн дундаж агаарын температурын явц /2011-2020 он/

3.3 Салхи

Сэлэнгэ аймаг нь Хангайн бүсэд хамаарагдах ба нөмөрлөж хаах уул, нуруу ихтэй учраас салхи багатай нутагт хамаарагдана. Хүчтэй шуургалж салхилах нь ховор. Олон жилийн дунджаас үзэхэд салхигүй үе нийт ажиглалтын 36 %-д байдаг байна. Салхины зонхилох чиглэл баруун ба баруун хойд талаасаа байдаг.



4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго.

Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлага тавьсан байдаг.

Эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгов.



5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал /сая.төг/	Эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар							
1	Цаг уурын нөхцөл байдал, уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт үүсэх	Уул уурхайн аюулгүй ажиллагааг хангах, орчны тоосжилтыг багасгах зорилгоор технологийн зам, талбайд тогтмол усалгааг хийж, хурдны хязгаарт хяналт тавих	Уурхайн бүсэд	1 км	Ажиллах хугацаанд	0,5	Агаарын тухай хууль, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)
2	Тээврийн хэрэгслүүдээс ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Техникийн үзлэг шалгалтыг тогмолжуулах	Уурхайн бүсэд	м³	Тогтмол	0,5	Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн талаар
3	Уурхайн ашиглалтын замд сайжруулалт хийх	Уурхайн зам талбайд хайрган материал дэвсэх Зам арчилгааны хуваарь гаргаж батлуулан мөрдөж ажиллах, холбогдох ажилтнуудаар батлуулах,	Уурхайн технологийн зам	1,2км	Тайлант он	Ү/а-ны зардлаас	Агаарын тухай хууль, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)



Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал /сая.төг/	Эрх зүйн баримт бичиг
Гадаргын ба газрын доорх усны нөөц							
1	Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх	Ашиглалтын худагт цэвэрлэгээ, ариутгалыг хийх	Тосгоны худагт	Сар бүр	Тайлант онд	Дотоодын нөөц бололцоонд тулгуурлан хийх	Усны тухай хууль,
2	Хаягдал усанд нөлөөлөх	Хаягдал усны дүгнэлтийг гаргуулах	Хаягдлын сан	1 удаа	2024 онд	-	Усны тухай хууль,
Хөрсөн бүрхэвч							
1	Техник болон хүний хүчин нөлөөгөөр хөрс болон ургамлыг гэмтээх	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулахгүй, хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах	Уурхайн төслийн талбайд	-	Байнгын хяналтанд авна	1.0	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016),
2	Шатах тослох материал асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Хаягдал тосыг зориулалтын саванд хадгалах уурхайн орчинд асгарч алдагдахаас сэргийлэх, аж ахуй нэгжид нийлүүлэх	Уурхайн төслийн талбайд	1 удаа	Тогтмол	Дотоодын нөөц бололцоонд	Асгаралтын журам



Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал /сая.төг/	Эрх зүйн баримт бичиг
Ургамлан нөмрөг							
1	Ургамлын нөмрөг доройтох цөлжилт үүсэх	Орон нутаг, үндэсний хэмжээний хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх.	Орон нутгаас заагдсан талбайд	12,500ш	10-р сард	-	МУ-н Ерөнхийлөгчийн зарлиг тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд
Амьтны аймаг							
1	Шувуу, нүүдлийн амьтанд	Биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Орон нутагт	Давс, хужир	11,12 саруудад	1,5	“Амьтны тухай” хууль, Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр,
2	Амьтны аймгийн хамгаалал	Ажилчдад ан амьтан зөвшөөрөлгүйгээр устгах, мал амьтны хулгайн гэмт хэргийг мэдээллэж байх талааар сургалт зохион байгуулах	Нийт ажилчдад	Улирал тутамд	7-р сард	Үа-ны зардлаас	Амьтны тухай” хууль




6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолын хавсралт, “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон талбайн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхээр тусгагдсан байдаг. Үүний дагуу орон нутгаас ирүүлсэн саналыг үндэслэн 3 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх болсон.

Мөн онд Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээний дагуу 2023 онд ордын баруун зүүн биетийг холбосон технологийн замыг техникийн нөхөн сэргээлт хийсэн 1,1га талбайг биологийн нөхөн сэргээлт хийж, хүлээлгэж өгөхөөр төлөвлөж байна

2024 онд төлөвлөсөн биологийн нөхөн сэргээлт хийх дэвсгэр зураг



Бүлэг	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, сая	Эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Олборлолтын улмаас эвдэрсэн газар Цагаан шилүүстэй	га	га	3	1 удаа	Дотоод үйл ажиллагаас	MNS4918:2000
2	Биологийн нөхөн сэргээлт	Уурхайн технологийн замыг нөхөн сэргээх	га	га	1.1	1 удаа	1.5	MNS 5918 : 2008

7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой түүх соёлын өвийг хамгаалах ажил хийгдэхгүй болно.

8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, сая	Эрх зүйн баримт бичиг
1	Ойжуулалт	Ойн зурвас газрыг нөхөн сэргээх	га	5га	12,5	10-р сард	8,0	MNS 5918 : 2008



9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор хог хаягдлын зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд төлөвлөгөөний зорилго оршино. Хүний амьдрах орчин, эрүүл мэндэд учруулах хог хаягдлын сөрөг нөлөөг илрүүлэн зохих арга хэмжээ авахад хэрэглээ, бүтээгдэхүүний сонголтыг харгалзах, хог хаягдлын урсгалыг хянах, бүртгэлжүүлэх, дахивар хүлээн авагчийг судалж хаягдлын анги тус бүрээр нийлүүлэхэд анхаарна.

Бид хог хаягдлыг ангилж чадвал баялаг гэсэн уриатай ажиллаж байна.

Бүлэг	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Нийт зардал, сая ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн, Үйлдвэрийн	Хог хаягдлыг төрөл тус бүрээр ангилан ялгах, дотоод гадаад орчны хог цуглуулах савны стандартыг сайжруулах	Уурхайн болон хотхоны хэмжээнд	Тухай бүрт	Тайлант онд	1,2	Хог хаягдалын тухай хууль
2	Ахуйн, Үйлдвэрийн	Төслийн талбайн ойр орчмын 50м радиуст талбайн цэвэрлэгээг тогтмол хийх	Төслийн талбайд	Тухай бүрт	Тайлант онд	Үйл ажиллагааны зардлаас	Хог хаягдалын тухай хууль
3	Ахуйн, Үйлдвэрийн	Хог хаягдлын түр хадгалах цэгийн ойр орчимд ариутгал халдваргүйтгэлийг хийлгүүлэх	Төслийн талбайд	Улиралд 1 удаа	Тайлант онд	Үйл ажиллагааны зардлаас	Хог хаягдлын тухай хууль
4	Бүх төрөл	Үйл ажиллагаанаас гарч буй бүх хог хаягдлын зохицуулалтад хяналт тавих, бүртгэл хөтлөх	Уурхайн хэмжээнд	Сар бүр	Тайлант онд	Үйл ажиллагааны зардлаас	Хог хаягдлын тухай хууль



5	Аюултай	Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, таних тэмдэг, санамж байрлуулах.	Төслийн талбайд	2-н цэгт	Хагас жилд нэг удаа	0,6	Аюултай бодисыг хадгалах тээвэрлэх, ашиглах, устгах журам
6	Аюултай	Эмнэлгийн хог хаягдлыг сумын эмнэлэгтэй гэрээ байгуулан устгах.	Хүдэр сум	0,1 кг	Улиралд 1 удаа	0,2	Хог хаягдлын тухай хууль
7	Аюултай	Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангах, шилжүүлэх	Уурхайн талбай	1 тн	Хагас жилд нэг удаа	0,2	Аюултай бодисыг хадгалах тээвэрлэх, ашиглах, устгах журам
						2,2 сая	



10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Байгалийн давтагдашгүй хүчин зүйлс	Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад сургалт зохион байгуулах. Цаг агаарын гэнэтийн байдал цасан болон шороон шуурга, үер усны аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар ажилчиддаа зааварчилгааг өгөх.	Төслийн талбайд	-	1-2 удаа	Улиралд 1 удаа	Цаг агаарын мэдээний журам.
2	Галын аюулаас урьдчилан сэргийлэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэлээр хангаж ажиллах. Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах	Уурхайн төслийн талбайд	-	1 удаа	Тайлант онд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, 13.2. Гал гарч болзошгүй ажлын байр бүрт байрлуулан, тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгаж, ажилтныг уг тоноглолыг ашиглаж сургасан байна.



Бүлэг	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3	Галын аюулаас урьдчилан сэргийлэх	Ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулах	Уурхайн төслийн талбай, ажилчдын амрах байранд	-	2 удаа	Тайлант онд	ХАБЭА-н тухай хууль, Гамшигаас хамгаалах хууль

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Агаарын чанарын хяналт шинжилгээ					
Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Давтамжийн тоо	Нийт зардал, сая.₮	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
PM2.5, PM10, нийт тоосонцор	Уурхайн тосгон, Үйлдвэр	1	0,3	Хүчин төгөлдөр хэмжилт хийх, дата боловсруулах, багажны хэвийн үйл ажиллагааг хангах	MNS 4048:1988 ISO 16017-1:2000 ISO 16362-2:2003 MNS 5365:2004 MNS-5919:2008 MNS ISO 4226:2000



Утааны хий: Хүхэрлэг хий, Азотын давхар исэл, Угаарын хий	Утааны хий	1	0,2	SO ₂ -20 мкг/м ³ NO ₂ -40 мкг/м ³ CO-30000 мкг/м ³	MNS 0017-2-5- 12:1988 MNS ISO 4221: 2002 MNS0012-1-003:1982 MNS 0017-2-5- 11:1988
Хөрсөн бүрхэвчийн хяналт					
Хөрсний чанар хүнд металлын шинжилгээ	Уурхайн засварын хэсэг, ШТС орчим, Үйлдвэрийн орчим	1	0,5	Сэлэнгэ аймаг УЦЦОХШГ-аар хийлгэх,	Хөрсний шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 3298:1990
Хөрсний чанар- нянгийн шинжилгээ	Кемп, орчим,засварын талбай,	1		Сэлэнгэ аймаг УЦЦОХШГ-аар хийлгэх	Нянгийн шинжилгээ.
Усан орчны хяналт шинжилгээ					
Усны ерөнхий үзүүлэлт ба хүнд металл	Гал тогооны худаг	1	0,5	Газрын доорхи ус: pH-6.5 – 8.5 NH ₄ - 3.0 мгN/л NO ₂ – 1 мг/л Ag-0.1 мг/л Fe-0.3 мг/л	MNS ISO 5667-10 : 2001
	Төмөртэйн гол	1			MNS ISO 5667-11:2000
	Шүүрлийн ус / баруун уурхай/	1			MNS ISO 5667- 13 :2000
			1,5 сая		



12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая ₮	Улирал				Хариуцах ажилтан	Тайлбар
			1	2	3	4		
1	Уурхайн бичиг баримтын бэлэн байдлыг хангах	0.5	Орон нутгийн ЗДТГ болон ААН-тэй гэрээ байгуулах хэрэгжилтийг ханган ажиллах				Төслийн удирдлага Байгаль орчны мэргэжилтэн	Захиалагчтай газар, ус ашиглах гэрээ байгуулах, зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулах /хог хаягдал, хаягдал тос/
2	Байгаль орчны мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтанд хамруулах	0.3	Тайланд онд				Үйл ажиллагаа хариуцсан захирал	
3	БОМТ-ийг тайлагнах хурлыг зохион байгуулахад оролцох, холбогдолтой тайлан мэдээ бэлтгэх	Үйл ажиллагааны зардлаас	Сар бүр хэрэгжилтийн явцыг тайлагнах				Байгаль орчны мэргэжилтэн	
4	Төсөл хэрэгжүүлэгчийн БО ажлын хүрээнд хийгдэж буй ажлуудад техникийн болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх	Үйл ажиллагааны зардлаас	Төслийн менежер Байгаль орчны мэргэжилтнүүд				Төсөл хэрэгжүүлэгчийн БО ажлын хүрээнд хийгдэж буй ажлуудад техникийн болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх	Үйл ажиллагааны зардлаас
5	Хамтран гүйцэтгэгч байгууллага компаниудын хяналтыг сайжруулах	0.5	Тайлант онд				Төслийн талбай дахь нийт ажилчид	
		1,3 сая						



12. ТЭР БУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих, байгалийн тэнцвэртэй байдлыг хадгалах, цөлжилтийг багасгах, усны нөөцийг хадгалах зэрэгт ногоон орчин бүрдүүлж мод тарих нь чухал үүрэгтэй. Тиймээс тухайн бүс нутагт мод тариалах ажлыг шат дараатай явуулахаар төлөвлөсөн. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ойн ангитай хамтарч 2024 онд 5 га талбайд 2,500 ш модыг тарихаар төлөвлөөд байна.

<i>Хийгдэх ажил</i>		<i>Хэмжих нэгж</i>	<i>Тоо хэмжээ</i>	<i>Нэгжийн үнэ, төг</i>	<i>Нийт зардал, сая.төг</i>
Мод тарих	Нарс	5 га	2500 ш	1500	8,0

13. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

<i>БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд</i>	<i>Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр</i>	<i>Мэдээний агууллага</i>	<i>Хугацааны тов</i>	<i>Хэлэлцүүлгээр санал авах чиглэл</i>	<i>Зохион байгуулах газар</i>	<i>Төсөв /сая.төг/</i>
Сэлэнгэ аймгийн Хүдэр сум	БОМ-ийн төлөвлөгөөг боловсруулж, цахимд шивэх	Төлөвлөгөөний хэрэгжилт	11 сард	БОХамгаалах, орон нутгийн санал	Сэлэнгэ аймаг, Хүдэр сумын захиргаа	0,5
Сэлэнгэ аймгийн БОАЖГ	Илтгэл, тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт	12 сард	БОХамгаалах, ажлын хэсгийн санал	Сэлэнгэ аймаг аймаг, БОАЖГ-г	0,5
						1,0 сая



